

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 14 дэх дугаарыг бэлтгэж, эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн “Судалгаа” хэсгээс Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх зарим асуудал; Шилжин суурьшигчдад зориулсан оюуны хөрөнгө оруулалт, түүний үр дүн; Сонсголтой болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн хооронд харилцан ойлголцох боломж судалгаа; Улаанбаатар хотын төвийн болон захын дүүргүүдийн ядуурлын ялгаатай байдал; Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс зэрэг хүн амын эрүүл мэнд, нийгмийн бүлгүүдийн асуудлыг хөндсөн сонирхолтой судалгааны ажлуудтай танилцах болно.

Түүнчлэн, “Үзэл бодол” хэсгээс та бүхэн эрүүл мэндийн салбарт үүсч буй авилгын хэлбэрүүд, тэдгээртэй хэрхэн тэмцэх шаардлагатай байгаа талаар судлаачийн хийсэн харьцуулалт, санал бодлыг уншиж өөрийн эргэцүүллийг хийх боломжтой.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй судалгаа, шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар уншигч та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Эцэст нь, Монгол улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, оюутан, залуучууд та бүхэндээ болон сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин Төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ